

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРИМ ЧИГ, ҮҮРГИЙГ ТӨРИЙН БУС  
БАЙГУУЛЛАГААР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ГЭРЭЭ

2016 оны 6 дугаар  
сарын 8 ний өдөр

Дугаар 109

Улаанбаатар хот

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8 дахь заалт, Засгийн газрын 1995 оны 111, 2016 оны 165 дугаар тогтоолыг тус тус үндэслэн төрийн байгууллагын зарим чиг, үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхтэй холбогдон институтын хүлээх үүрэг, хариуцлага, түүний үйл ажиллагаанд хяналт тавих, чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах зорилгоор Нэг талаас Сангийн яам, түүнийг төлөөлж Сангийн сайд Б.Болор (цаашид "үүрэг гүйцэтгүүлэгч" гэх) нөгөө талаас Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт, түүнийг төлөөлж Институтын ерөнхийлөгч Ц.Жигдэн(цаашид "үүрэг гүйцэтгүүлэгч" гэх) нар (хамтад нь "талууд" гэх) доорх нөхцлийг харилцан тохиролцож, энэхүү гэрээг байгуулав.

ХОЁР. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 2.1. Тус гэрээгээр үүрэг гүйцэтгэгч нь дор дурдсан төрийн байгууллагын зарим чиг үүргийг үүрэг гүйцэтгүүлэгчийн тогтоосон төлбөрийн дээд хязгаарт багтааж, иргэн хуулийн этгээдэд түргэн шуурхай, чанартай гүйцэтгэхэд оршино.
- 2.1.1. Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох, сунгах шалгалт, сургалт зохион байгуулах аудитын үйл ажиллагааны стандарт, мэргэжлийн ёс зүйн дүрмийг зөрчсөн аудиторын мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийг хүчингүй болгох;
- 2.1.2. Мэргэшсэн нягтлан бодогч, аудиторын ёс зүйн дүрмийг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;
- 2.1.3. Нягтлан бодох бүртгэл, аудитын олон улсын стандарт, түүний нэмэлт, өөрчлөлтийг орчуулах, хэрэглэх, тайлбар, зөвлөмж боловсруулан гаргах, аж ахуйн нэгж байгууллагын стратеги засаглал, гүйцэтгэл, хэтийн хандлагын уялдааг харуулсан бусад тайлагналын аргачлалыг боловсруулах;
- 2.1.4. Аудитын хуулийн этгээдийг мэргэжил, арга зүйн удирдлага, зөвлөгөө, мэдээллээр хангах;
- 2.2. Үүрэг гүйцэтгэгч нь тус гэрээний 2.1.1-д заасан төрийн үйлчилгээг үзүүлэхдээ мэргэшсэн нягтлан бодогчид эрх олгох болон эрх сунгах сургалтыг төлбөртэй зохион байгуулж болох бөгөөд 1 цагийн сургалтын төлбөрийндээд хязгаарыг 2 500 /хоёр мянга таван зуун / төгрөг байхаар тооцно.
- 2.3. Үүрэг гүйцэтгэгч нь хуулийн шаардлага хангасан мэргэшсэн нягтлан бодогчийн эрх горилогчоос авах шалгалтыг төлбөртэй авч болох бөгөөд 1 цагийн шалгалтын үйлчилгээний төлбөрийн дээд хязгаарыг 3 000 /гурван мянга/ төгрөг байхаар тооцно.
- 2.4. Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх горилогчоос авах шалгалтын зохион байгуулалтыг үүрэг гүйцэтгэгч хангаж, шалгалтыг Сангийн сайдын тушаалаар байгуулагдсан шалгалтын ажлын хэсэг авах бөгөөд шалгалтын үр дүнг шалгалт дууссанаас 3 цагийн дотор Мэргэшсэн нягтлан бодогчдын институтын албан ёсны [www.testaccount.monicpa.mn](http://www.testaccount.monicpa.mn) цахим хуудсанд байршуулна.
- 2.5. Мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийн хугацаа дууссан этгээд нь эрх горилогч этгээдтэй нэгэн адил сургалтад хамрагдаж, шалгалт өгч эрхээ сунгуулна.

- 2.6. Гэрээний 2.4-т заасан шалгалтад тэнцсэн эрх горилогчид Мэргэшсэн нягтлан бодогчдын инситутын төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тогтоолоор мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийг 4 жилийн хугацаатай олгоно.
- 2.7. Үүрэг гүйцэтгэгч нь олон улсын стандарт, Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн сургалтын агуулгыг боловсруулж, сургалтад хамрагдаж буй эрх горилогчдыг сургалтын материалаар бүрэн хангаж, шалгалтад зориулж хичээл бүрээр иж бүрэн тестийн сан бүрдүүлэн, үнэн зөв байдлыг хариуцна.
- 2.8. Үүрэг гүйцэтгэгч нь Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 199 дүгээр тогтоолын дагуу Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогчийн 4 жилийн болон хугацаагүй эрх олгох шалгалтад тэнцсэн иргэний улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримтын хуулбар хувь, төлсөн татварын хэмжээг нэгтгэсэн жагсаалтыг шалгалтын дүн нийтлэгдснээс 15 хоногийн дотор Сангийн яам болон холбогдох байгууллагад нь хүргүүлнэ.

**ГУРАВ. САНХҮҮ, БҮРТГЭЛИЙН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ**

- 3.1 Үүрэг гүйцэтгүүлэгч нь үүрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагаа түүний дүрэм журам болон энэ гэрээнд заасны дагуу явагдаж байгаа эсэх талаар дүгнэлт гарган, үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг хянан, арга хэмжээ авч, шийдвэр гаргах эрхтэй.
- 3.2 Үүрэг гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгчийн санаачлагаар тус гэрээг хэсэгчлэн болон бүхэлд нь хүчингүй болгох бүрэн эрхтэй.
- 3.3 Үүрэг гүйцэтгүүлэгч нь гэрээний хугацаанд үүрэг гүйцэтгэгчийн гүйцэтгэх ажлын даалгаврыг тус гэрээнд хавсаргаж, гарын үсэг зурж баталгаажуулна.

**ДӨРӨВ. МОНГОЛЫН МЭРГЭШСЭН НЯГТЛАН БОДОГЧДЫН ИНСТИТУТИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

- 4.1 Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон энэхүү гэрээний дагуу Институт дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.
  - 4.1.1. Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох, эрхийг хүчингүй болгох;
  - 4.1.2. Мэргэшсэн нягтлан бодогчийн 4 жилийн болон хугацаагүй эрх олгох шалгалтад зориулсан сургалтын хөтөлбөрийг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан боловсролын стандартад нийцүүлэн боловсруулж, мөрдүүлэх
  - 4.1.3. Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас өгсөн чиглэл удирдамжийн дагуу нягтлан бодох бүртгэл, аудитын олон улсын стандарт, түүний нэмэлт, өөрчлөлтийг орчуулах, үндэсний стандарт боловсруулах, хэрэглээний тайлбар, зөвлөмжийн төслийг боловсруулж хүргүүлэх;
  - 4.1.4. Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас өгсөн чиглэл удирдамжийн дагуу аудитын хуулийн этгээдийн үйл ажиллагаанд баримтлах арга зүйн удирдамж, зөвлөмж боловсруулан гаргах, тэдгээрийг мэдээллээр хангах;
  - 4.1.5. Аж ахуйн нэгж, байгууллагын стратеги, засаглал, гүйцэтгэл, хэтийн хандлагын уялдааг харуулсан тайлагналын аргачлалыг боловсруулах;

- 4.1.6 Мэргэшсэн нягтлан бодогчдыг гишүүнээр элсүүлэх, Олон улсын нягтлан бодогчдын холбооноос гаргасан стандартад нийцүүлэн гишүүдийн ёс зүйн дүрмийг боловсруулан, баталж, мөрдүүлэх;
- 4.1.7 Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институтын гишүүн, гишүүнчлэлтэй байгууллагуудын татварын хэмжээ, сургалт, шалгалтын хураамжийн хэмжээг Сангийн яамтай тохирилцон тогтоож мөрдүүлнэ.
- 4.1.8 Дүрэм болон дотоод журмын дагуу үйл ажиллагааны ил тод байдлыг ханган, эрх бүхий албан тушаалтан болон ажилтныг сонгон шалгаруулах болон сонирхлын зөрчлөөс сэргийлэх зарчмыг баримтлан ажиллах.
- 4.1.9 Гэрээ болон ажлын даалгаварын биелэлтийн тайланг Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухайн оны 12 дугаар сарын 5-ны дотор бичгээр ирүүлж дүгнүүлнэ.
- 4.1.10 Үүрэг гүйцэтгэгч өөрийгөө санхүүжүүлэх зарчмын дагуу үйл ажиллагаа явуулна.

#### ТАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1 Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг гэрээний нөгөө талаас шаардах эрхтэй.
- 5.2 Гэрээний биелэлтийг хангахад технологийн болон эрх зүйн орчинд өөрчлөлт шинэчлэлт гарсан тохиолдолд хамтын ажиллагааг тэдгээрт нийцүүлэх талаар санаачлага гаргаж ажиллана.

#### ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ САНХҮҮЖИЛТ

- 6.1 Тус гэрээний санхүүжилт нь гэрээний 2.1-т заасан үйлчилгээ үзүүлсэний төлбөр болон гишүүнчлэлийн татварын орлогоос бүрдэнэ.
- 6.2 Гишүүнчлэлийн жилд төлөх татварын дээд хязгаар нь дор дурдсанаас хэтрэхгүй байна.
- 6.2.1. Иргэний хувьд төлөх татварын дээд хэмжээ 120000 / нэг зуун хорин мянга / төгрөгөөс хэтрэхгүй байна.
- 6.2.2. Дотоодын хуулийн этгээдийн хувьд төлөх татварын дээд хэмжээ нь аудитын үйлчилгээний орлогоос нь хамааран тооцох бөгөөд 2000000 /хоёр сая/ төгрөгөөс хэтрэхгүй байна.
- 6.2.3. Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн хувьд төлөх татварын дээд хэмжээ нь аудитын үйлчилгээний орлогын 0,5 хувиас хэтрэхгүй байна.
- 6.4 Үүрэг гүйцэтгэгч нь тус гэрээний 4.1.-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэхдээ гэрээний 2.2, 2.3, 6.2-д зааснаас бусад аливаа төлбөр хураамж татвар зэргийг гишүүд болон хуулийн этгээдээс авахгүй.

#### ДОЛОО. ХАРИУЦЛАГА

- 7.1 Хүлээн авсан мэдээллийг боловсруулж, ашиглах явцад байгууллагуудын холбогдох хууль тогтоомж зөрчигдсөн байж болзошгүй тохиолдолд илэрсэн зөрчил дутагдлыг харилцан мэдээлэх, зөрчлийг арилгах талаар хамтран ажиллана.

7.2 Энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс мэдээлэлд дурьдагдсан этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн тал хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

### НАЙМ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

8.1 Гэрээний үүргийн биелэлттэй холбогдуулан гарах аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ.

7.2 Хэрэв талууд харилцан зөвшилцөж чадахгүй бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

### ЕС. БУСАД ЗҮЙЛ

9.1 Энэхүү гэрээ нь талуудын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

9.2 Гэрээг 2эх хувь үйлдэж, Талууд тус бүр 1 хувийг хадгалсан нь хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

9.3 Талууд энэхүү гэрээгээр хүлээх эрх үүргээ бүхэлд нь эсвэл хэсэгчлэн бусдад шилжүүлэхгүй.

9.4 Гэрээний талуудын үйл ажиллагааны чиглэл, нэр, удирдлага зохион байгуулалтад аливаа өөрчлөлт орсон тохиолдолд тухайн үйл ажиллагааг залгамжлан хэрэгжүүлэх байгууллага нь энэхүү гэрээний эрх, үүргийг шууд хүлээн авах ба гэрээний үүрэг заавал биелэгдэх шинжтэй байна.

9.5 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр хийх бөгөөд гэрээнд оролцогч бүх Талуудын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр гэж тооцогдоно.

Ийнхүү оруулсан нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний нэгэн адил хүчинтэй байж, гэрээний салшгүй хэсэг байна.

9.6 Энэхүү гэрээгээр зохицуулаагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоор зохицуулж, түүнийг удирдлага болгоно.

9.7 Энэхүү гэрээ нь 2017 оны 12 дугаар сарын 31-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

САНГИЙН ЯАМЫГ ТӨЛӨӨЛЖ

САНГИЙН САЙД  
Б.БОЛОР

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН  
БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА  
Б.ДОРЖСЭМБЭД



МОНГОЛЫН МЭРГЭШСЭН  
НЯГТЛАН БОДОГЧДЫН  
ИНСТИТУТЫГ ТӨЛӨӨЛЖ:

ИНСТИТУТЫН ГЭРЭЭНХИЙЛӨГЧ

УИЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
ЦОЙЧИМИДСҮРӨН  
Certified Public Accountants

